



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/211

Мөрөн

Гүйцэтгэлийг сайжруулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14.2.3, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 29.1.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудитаар аймгийн Аудитын газраас өгсөн зөвлөмж, албан даалгаварын хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийг сайжруулах төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллахыг бүх шатны төсөв захирагч, холбогдох хэлтэс, агентлагын дарга нарт үүрэг болгосугай
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д даалгасугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР

Аймгийн Засаг даргын 2015 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/211 дүгээр захирамжийн хавсралт

ГҮЙЦЭТГЭЛИЙГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх ажлын нэр	Хариуцах албан тушаалтан	Хугацаа
1	Аймгийн ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил, алдаа дутагдалд дүгнэлт хийж, зөрчлийг арилгах, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг бүх шатны төсөв захирагчдаар гаргуулах, гүйцэтгэлийг тооцон ажиллах	СТСХэлтэс, ерөнхий санхүүч Ц.Мөнхтуяа	Төсвийн жилд
2	2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай болон сөрөг дүгнэлт авсан төсөвт байгууллагын холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох	Аймаг, сумын Засаг дарга нар болон төсөв захирагчид	2015 оны 6 дугаар сарын 10-ний дотор
3	Хүлээлцсэн комиссын актгүйгээр орлогод авсан хөрөнгүүдийн баримт, материалыг бүрдүүлэх	Сумдын санхүүгийн албаны дарга нар болон төсөвт байгууллагын нягтлан бодогч нар, БСГ-ын мэргэжилтэн Н.Далайжаргал	Хагас жилийн санхүүгийн тайлангаар
4	Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын ТЭЗҮ-г ажил бүрээр нягталж үзэх, хэрэв ТЭЗҮ нь бүрэн хийгдээгүй ажлууд байгаа бол жагсаалтыг гаргаж, аймгийн ТЕЗ-д танилцуулах, санхүүжүүлэхгүй байх арга хэмжээ авах	Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Х.Ган Очир, мэргэжилтэн С.Дамдиндорж, Э.Аззаяа	2015 оны 6 дугаар сарын 25-ний дотор
5	Сумын ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын ТЭЗҮ-г ажил бүрээр нягталж үзэх, хэрэв ТЭЗҮ нь бүрэн хийгдээгүй ажлууд байгаа бол жагсаалтыг гаргаж, сумын ТЕЗ-д танилцуулах, санхүүжүүлэхгүй байх арга хэмжээ авах	Сумдын Засаг даргын орлогч, сумын санхүүгийн албаны дарга нар	2015 оны 6 дугаар сарын 25-ний дотор
6	Аймаг, сумын ОНХСангийн хөрөнгөөр 2015 онд хийгдэх ажлын ТЭЗҮ-г шалгаж, ТЭЗҮ боловсрогдоогүй байхад төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг илрүүлэх, дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	2015 оны 6 дугаар сарын 25-ний дотор
7	Аймаг, сумын ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хийгдэх ажлын төлөвлөгөөний төсөлд тусгагдсан ажлуудыг ТЭЗҮ-д шалгалт хийж дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, ХБХэлтэс	2015 оны 6 дугаар сарын 25-ний дотор
8	Төсвийн жил дамжиж хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гэрээг нийт төсөвт өртгөөр нь болгож шинэчлэх	Аймгийн ХАААлба	2015 оны 6 дугаар сарын 25-ний дотор
9	ОНХСангийн өр 2385.7 сая төгрөгийг бүртгэлд хэрхэн тусгах талаар Сангийн яаманд тоот төлөвлөж явуулах	СТСХэлтэс, ерөнхий санхүүч Ц.Мөнхтуяа	2015 оны 6 дугаар сарын 1-ний дотор
10	ОНХСангийн өр 2385.7 сая төгрөгийг бүртгэлд хэрхэн тусгах талаар Сангийн яамнаас тоотын хариуг авсны үндсэн дээр өр тусгах эсэхийг шийдвэрлэх	СТСХэлтэс, ерөнхий санхүүч Ц.Мөнхтуяа	2015 оны 7 дугаар сарын 1-ний дотор
11	Аймгийн ТЕЗ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулах	СТСХэлтэс, ерөнхий санхүүч Ц.Мөнхтуяа	Төсвийн жилд
12	Төрийн сангийн бодлогын баримт бичгийг шинэчлэн батлуулах	СТСХэлтэс, ерөнхий санхүүч Ц.Мөнхтуяа	Төсвийн жилд

13	Төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шаардлагад нийцүүлэн шинэчлэх ажлыг зохион байгуулах	СТСХэлтэс, ерөнхий санхүүч Ц.Мөнхтуяа, сумын санхүүгийн албаны дарга нар	Төсвийн жилд
14	Аймаг, сумын төсвийн орлогын гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр харьцуулсан шинжилгээ хийж, дүгнэлт гаргах	СТСХэлтэс, төсвийн орлогын мэргэжилтэн Х.Энхтуяа	Төсвийн жилд
15	Аймаг, сумын төсвийн зарлагын гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр харьцуулсан шинжилгээ хийж, дүгнэлт гаргах	СТСХэлтэс, төсвийн зарлагын мэргэжилтэн Б.Базар, БСГ-ын мэргэжилтэн Н.Далайжаргал, ЭМГ-ын мэргэжилтэн Б.Батчимэг	Төсвийн жилд
16	Төсвийн орлого бүрдэлтийн талаар холбогдох хэлтэс, тасаг, сумдтай хамтран ажиллах, төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтэд дүн шинжилгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангах, холбогдох шийдвэрийг гаргуулах	СТСХэлтэс, төсвийн орлогын мэргэжилтэн Х.Энхтуяа	Сар бүр
17	Төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар талаар холбогдох хэлтэс, тасаг, сумдтай хамтран ажиллах, төсвийн зарлагын төлөвлөгөөний биелэлтэд дүн шинжилгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангах, холбогдох шийдвэрийг гаргуулах	СТСХэлтэс, төсвийн зарлагын мэргэжилтэн Б.Базар	Сар бүр
18	Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах байгууллагуудын авлагын насжилтад шинжилгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулах	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	2015 оны 7 дугаар сарын 1-ний дотор
19	Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах байгууллагуудын өглөгт шинжилгээ хийж, өглөг үүссэн шалтгааныг байгууллага бүрээр тодорхойлох, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулах	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	2015 оны 7 дугаар сарын 1-ний дотор
20	Ус болон ургамал ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлтөд аудит хийж, дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, СТСХэлтэс Х.Энхтуяа	2015 оны 8 дугаар сарын 1-ний дотор
21	Иргэд, аж ахуйн нэгжид сүүлийн 3 жилд газрын төлбөр ногдуулалт, төлөлтөд аудит хийх, дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, СТСХэлтэс Х.Энхтуяа	2015 оны 9 дугаар сарын 1-ний дотор
22	Төсөвт байгууллагуудын бараа материалын үлдэгдэлд аудит хийх, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэр гаргуулах	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	2015 оны 11 дугаар сарын 1-ний дотор
23	Шилэн дансны мэдээлэлд хяналт, мониторинг хийх, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулах	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	Улирал бүр
24	Тэг үлдэгдэлтэй дансны өдөр тутмын хаалтад хяналт тавих, төрийн санд хаагдсан улс, аймаг, сумын төсвийн орлогыг улирлаар төрийн сантай тооцоо нийлэх	Татварын хэлтэс, сумын татварын байцаагч, аймаг сумын төрийн сан	Улирал бүрийн дараа сарын 5-ны дотор
25	Төсөвт байгууллагын бэлэн мөнгөний үйлчилгээ үзүүлэх картын дансны хяналтыг түүвэрчлэн хийх	СТСХэлтэс, дотоод хяналтын мэргэжилтэн	Төсвийн жилд
26	Арилжааны банкинд нээгдсэн дансны тоо болон гүйлгээ дамжиж байгаа эсэх талаарх хяналтыг хийх, сар бүр банкнуудаас мэдээ авах, зөвшөөрөлгүй нээгдсэн дансуудыг хаах арга хэмжээ авах	Аймгийн төрийн сангийн дотоод хяналтын мэргэжилтэн, сумын төрийн сангийн мэргэжилтэн	Сар бүр
27	Төсвийн гүйцэтгэлийн мэдээ гаргалтын чанарыг сайжруулах, мэдээний дүнг аймаг, сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, тухай	СТСХэлтэс, ерөнхий санхүүч Ц.Мөнхтуяа, сумын санхүүгийн албаны дарга нар	Сар бүр

	бүр холбогдох шийдвэрийг гаргуулах		
28	Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргалтын чанарыг сайжруулах, тайлангийн мэдээлэлтэй холбоотой холбогдох баримтуудын бүрдлийг сайжруулах, тулгалт хийх	СТСХэлтэс, ерөнхий санхүүч Ц.Мөнхтуяа, сумын санхүүгийн албаны дарга нар	Хагас, бүтэн жилээр
29	ОНӨҮГ-уудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үзлэг хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, зөвлөмжийн биелэлтийг хангуулах	СТСХэлтэс, бүртгэлийн мэргэжилтэн Т.Энхтуяа	Төсвийн жилд
30	ОНӨҮГ-уудын ашигт ажиллагааг хангаж ажиллах талаар аймаг, сумын ИТХ-тай хамтран ажиллах	СТСХэлтэс, бүртгэлийн мэргэжилтэн Т.Энхтуяа, ХБХэлтэс	Төсвийн жилд
31	Эмийн эргэлтийн сангийн талаар баримтлах бодлого чиглэлийг тодорхойлох	НХХэлтэс мэргэжилтэн Цэндмаа, Эрүүл мэндийн газар,	Төсвийн жилд
32	Сангийн яамны дамжуулан зээлдүүлэх өрийг төлж эхлэх	Ус чандмана, УСНААК, Хөвсгөл эрчим хүч	Төсвийн жилд
33	ХЯБХ-ийн малжуулах төслийн өрийг барагдуулах ажлыг зохион байгуулж үр дүнг тооцон ажилах	ҮХАА-н газрын дарга Б.Галбадрах, сумын Засаг дарга нар	Төсвийн жилд
34	Хөвсгөлийн бүргэдүүд ХХК-ийн өрийг барагдуулах, Шүүхийн шийдвэрийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Мал хамгаалах сангийн ня-бо Батсайхан	Төсвийн жилд
35	Лидер кашмер ХХК-ийн өрийг барагдуулах	ХБХэлтэс П.Ууганбаяр	Төсвийн жилд
36	Малжуулах төслийн өрийг барагдуулах /ЗГ-ын 2010 оны 197-р тогтоолоор олгосон/	ҮХАА-н газрын дарга Б.Галбадрах, сумын Засаг дарга нар	Төсвийн жилд
37	Мал хамгаалах сангийн өр, авлагыг барагдуулах	Мал хамгаалах сангийн ня-бо Батсайхан	Төсвийн жилд
38	Мал хамгаалах сангийн журмыг АИТХ-аар батлуулах	ХБХэлтсийн дарга Х.Ган Очир ҮХАА-н газрын дарга Б.Галбадрах	2-р улиралд
39	ЖДҮ-ийг дэмжих зорилгоор ХААН банкинд байршуулсан зээлийн эргэн төлөлт, ашиглалтын талаар мониторинг хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, холбогдох шийдвэр гаргуулах	ХБХэлтсийн дарга Х.Ган Очир , мэргэжилтэн П.Ууганбаяр	Төсвийн жилд
40	Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шатнаас нь ашиглагч, ашиглалтаас гарах зардлыг санхүүжүүлэх байгууллагыг тодорхой болгон аль байгууллагын данс бүртгэлд тусгаж орлогод авах талаар шийдвэр гаргуулж Өмчийн алба болон, Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж байх	ХБХэлтсийн дарга Х.Ган Очир, мэргэжилтэн Д.Дамдиндорж,Ж.Жавзанпагма	Төсвийн жилд
41	ОНХСан, улс орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтээс нэмэгдсэн, сайжруулсан үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгах хяналтыг хийх	СТСХэлтэс, ерөнхий санхүүч Ц.Мөнхтуяа, сумын санхүүгийн албаны дарга нар	Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар
42	Зарим хөрөнгө оруулалтын ажлууд дээр зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зарлаж хяналт хийлгэх	ХААА-ны дарга Б.Болд	Төсвийн жилд